



[/Ерөнхийлөгчийн 2002 оны 78 дугаар зарлигаар хүчингүй болсон/](#)

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 81 дугаар зарлигийн хавсралт

ПРОКУРОРЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

1. Прокурорын мэргэжлийн зөвлөл /цаашид энэ журамд "зөвлөл" гэнэ/ нь Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 37 дугаар зүйлд зааснаар прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж дүгнэнэ.
2. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд түүнд өндөр мэргэшилтэй, ажил, амьдралын туршлагатай прокуроруудыг оруулна. Зөвлөлийн дарга нь Улсын ерөнхий прокурор байна.
Зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдийг ерөнхий прокурор батална.
Улсын ерөнхий прокурорын түр эзгүйд түүний даалгасан зөвлөлийн гишүүн зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэнэ.
3. Зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 1/ Улсын ерөнхий прокурорын шийдвэрийг үндэслэн нийт прокурорын үйл ажиллагаа, мэргэжлийн түвшинг шалгаж хүн нэг бүр дээр дүгнэлт гаргах;
 - 2/ Улсын ерөнхий прокурор шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж дүгнэлт гаргах.
4. Зөвлөлийн дарга нь гишүүний бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 1/ прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгах бүрэлдэхүүнийг зөвлөлийн гишүүд дотроос томилох;
 - 2/ зөвлөлийн хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг нь хангуулж удирдах;
 - 3/ шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн хүмүүсийг үндсэн байгууллагатай нь тохиролцсон үндсэн дээр шалгалтын ажилд татан оролцуулах.
5. Зөвлөлийн гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 1/ прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгах;
 - 2/ зөвлөлийн хуралдаанд таслах эрхтэй оролцох;
 - 3/ үүргээ гүйцэтгэхтэй холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн нууцыг чанд хадгалах.

6. Зөвлөл нь прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж дүгнэхдээ Прокурорын байгууллагын тухай хууль, хууль тогтоомжийн бусад акт, энэхүү журам болон Улсын ерөнхий прокурорын холбогдох тушаалыг мөрдлөг болгоно.

Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинд хийх шалгалтыг бичгээр, сонжуураар шалгах, ярилцлага хийх, тухайн прокурорын хянаж шийдвэрлэсэн хэрэг, өргөдөл, гомдол, мэдээлэл, эрхэлсэн ажлын үндсэн үзүүлэлт, холбогдох бусад бичиг баримттай танилцах, түүнчлэн прокурорын газрын удирдлага, хамт олны болон шаардлагатай гэж үзсэн бусад байгууллага, ажилтны үнэлэлтийг сонсох зэрэг аргаар явуулна. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгасан тухай Улсын ерөнхий прокурорт танилцуулна.

7. Зөвлөл өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн ирцтэй хэлэлцэнэ.

Шалгах бүрэлдэхүүний ахлагч, эзгүйд нь түүний даалгасан гишүүн шалгалтын талаар зөвлөлийн хуралдаанд танилцуулах бөгөөд гишүүд шалгах бүрэлдэхүүнээс асуулт тавьж хариулт авах, шалгалтын дүн, бусад баримт сэлттэй сайтар танилцсаны эцэст тухайн прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинд өгөх дүгнэлтийн талаар санал хураалт явуулна. Санал хураалтын дүнг хуралдааны тэмдэглэлд тусгана.

Хуралдааны тэмдэглэлд зөвлөлийн дарга, тэмдэглэл хөтөлсөн ажилтан гарын үсэг зурна.

8. Зөвлөлийн дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргана.

Дүгнэлтэд прокурор мэргэшил, ажил хэргийн чадварын хувьд ямар түвшинд байгаа, эрхэлсэн ажилдаа тэнцэх эсэх талаар тодорхой үндэслэл зааж дурдсан байна.

Дүгнэлтэд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна.

Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн талаар гаргасан зөвлөлийн дүгнэлт эцсийн байна.

9. Зөвлөлийн хуралдааны дэгийг Улсын ерөнхий прокурор батална.

10. Зөвлөлийн ажилд оролцсон байдлыг харгалзан гишүүдэд Улсын ерөнхий прокурорын шийдвэрээр жилд нэг удаа мөнгөн урамшуулал олгож болно.

11. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг прокурорын байгууллагын төсөвт тусгайлан тусгана.

Зөвлөлийн бичиг хэрэг, техникийн бусад үйлчилгээг Улсын ерөнхий прокурорын газар хариуцна.

12. Зөвлөл нь Улсын ерөнхий прокурорын газрын тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.